



**УЛСЫН ХОЁРДУГААР  
ТӨВ ЭМНЭЛЭГ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 49, Утас/Факс: (976) 7015 0308  
И-мэйл: info@ssch.gov.mn, Вэб: www.ssch.gov.mn

2023.11.27 № 5/973  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ИРГЭН,  
АЖ АХУЙН НЭГЖ, ТӨРИЙН БУС  
БАЙГУУЛЛАГАД

**Үнийн санал авах тухай**

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар төлөвлөсөн тул сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Сонирхогч нь зөвлөх үйлчилгээний урилгад хавсаргасан ажлын даалгавартай танилцаж, үнийн саналыг холбогдох материалын хамт 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 17 цаг 30 минутаас өмнө цахим болон цаасан хэлбэрээр дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

Жич: Сонирхогч этгээд нэмэлт мэдээллийг 2023 оны 11 дүгээр сарын 29-ний дотор Захиргаа, хүний нөөцийн албанаас авч болно.

Мэдээлэл авах цахим хаяг: [www.ssch.gov.mn](http://www.ssch.gov.mn). Үндсэн веб сайт, Ил тод байдал цэс,  
Худалдан авах ажиллагааны ил тод байдал.

И-мэйл: [info@ssch.gov.mn](mailto:info@ssch.gov.mn)

Хаяг. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн байр.

ЗАХИРАЛ



Я. АМАРЖАРГАЛ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2023.11.27.

№	Үндэслэл	Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах.
1.	Зорилго	Төрийн байгууллага түүний албан тушаалтны үйл ажиллагаа нийтэд ил тод нээлттэй байх, авлига ашиг сонирхолын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулж, олон нийтийн хяналттай болгох.
2.	Хамрах хүрээ	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үйл ажиллагаа, холбогдох албан тушаалтны үйл ажиллагаа
3.	Хүлээгдэж буй үр дүн	Байгууллагын болон албан тушаалтны үйл ажиллагааг олон нийтийн хяналттай болгосноор үйл ажиллагаа нь олон нийтэд нээлттэй ил тод болж нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.
4.	Хяналт хэрэгжүүлэх хэлбэр	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын 3.1-д заасан дараах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд: 1 “...төрийн байгууллагын цахим хуудасд мониторинг, дүн шинжилгээ хийж, тайлан, мэдээлэл, санал боловсруулах...” 2. “...төрийн байгууллагын үзүүлж буй үйлчилгээний явцад ажиглалт хийх, тайлан, мэдээлэл, санал боловсруулах...”
5.	Ажлын үр дүн, тавигдах шаардлага, төлөвлөгөө, хугацаа	Ажлын үр дүн, гүйцэтгэх арга хэлбэр, тайланд тавигдах шаардлага, ажлыг гүйцэтгэх хугацааг гэрээгээр зохицуулна.
6.	Хяналт хэрэгжүүлэгчид тавигдах шаардлага	<p><b><u>Ерөнхий шаардлага:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>• иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага;</li> <li>• хяналт хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мэдлэгтэй байх;</li> <li>• хяналт үнэлгээ, аудит, судалгаа хийж байсан туршлагатай байх;</li> <li>• Хууль тогтоомж, байгууллагын шийдвэрт анализ дүгнэлт хийх чадвартай, туршлагатай байх;</li> <li>• ажлыг даалгаврын дагуу бүрэн гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвартай байх;</li> <li>• төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлж байсан бол давуу тал болох.</li> </ul> <p><b><u>Тусгай шаардлага:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хяналт хэрэгжүүлэх байгууллага түүний албан тушаалтантай сүүлийн 2 жилийн хугацаанд хамтран ажиллаагүй байх (хөдөлмөрийн болон иргэний хуульд заасан холбогдох гэрээ);</li> <li>• Хяналт хэрэгжүүлэх байгууллага түүний албан тушаалтнаас сүүлийн 2 жилийн хугацаанд бэлэг, хандив, санхүүгийн дэмжлэг тусламж аваагүй мөн төлөөлөл хэрэгжүүлээгүй байх;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн гэр бүл, найз нөхөд, нэгдмэл сонирхолтой этгээд хяналт хэрэгжүүлэх байгууллагад ажилладаггүй байх;</li> <li>• Хяналт хэрэгжүүлэх байгууллагын эрх бүхий албан тушаалтантай хамаарал бүхий этгээд биш байх.</li> </ul>
7.	Хяналт хэрэгжүүлэгчийн бичиг баримт	<p>Шалгаруулалтад оролцогч шаардлага хангасан гэж үзвэл дараах бичиг баримт, материалыг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Иргэний үнэмлэх, аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм-хуулбар хувь;</li> <li>• Танилцуулга, ур чадварыг нотлох боловсролын диплом, мэргэжшлийн үнэмлэх гэх мэт;</li> <li>• Зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байдлыг нотлох баримт-сүүлийн 2 жилийн байдлаар;</li> <li>• Ажлыг бусдаас ялгарах байдлаар гүйцэтгэх талаархи танилцуулга;</li> <li>• Ажлын төлөвлөгөө;</li> <li>• Ерөнхий болон тусгай шалгуурыг хангаж байгаа талаархи мэдээллийг бичгэн хэлбэрээр ирүүлэх.</li> </ul>
8.	Төлбөр төлөх журам	Ажлын хөлсийг гэрээнд заасан журмаар гүйцэтгэлээр олгоно.
9.	Материал ирүүлэх хугацаа	<p>2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 17 цаг 30 минутаас өмнө ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мэдээлэл авах цахим хаяг: <a href="http://www.ssch.gov.mn">www.ssch.gov.mn</a>. Үндсэн веб сайт, Ил тод байдал цэс, Худалдан авах ажиллагааны ил тод байдал.</li> <li>• Цахим хэлбэрээр И-мэйл: <a href="mailto:info@ssch.gov.mn">info@ssch.gov.mn</a> хаягаар ирүүлнэ.</li> <li>• Цаасан хэлбэрээр ирүүлэх бол Улсын төв эмнэлгийн захиргааны байрны 2 давхарт Ерөнхий захирлын туслахад битүүмжилсэн байдлаар хүлээлгэн өгнө</li> </ul>
10.	Хаяг, утас	<p>Хаяг. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн байр. Утас: 976-70150222</p>